



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/711

Булган сум

Г Газар эзэмшүүлэх тухай Г

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан "Булган сумын шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Энхжаргал овогтой Нямдаваа (ГЭ88041818)-д Булган сум 6 дугаар баг Залуус 2 дугаар гудамж 211а тоотод байршилтай 520 м<sup>2</sup> газрыг амины орон сууц зориулалтаар, Цэдэндорж овогтой Батчимэг (ЛЮ79013161)-т Булган сум 6 дугаар баг Залуус 6 дугаар гудамж 622 тоотод байршилтай 585 м<sup>2</sup> газрыг амины орон сууц зориулалтаар, Мөнхбат овогтой Энхтуяа (ГЮ94081900)-д Булган сум 6 дугаар баг Залуус 2 дугаар гудамж 205а тоотод байршилтай 552 м<sup>2</sup> газрыг амины орон сууц зориулалтаар тус тус газрын дуудлага худалдааны анхны үнийг төлүүлэн 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Э.Нямдаваа, Ц.Батчимэг, М.Энхтуяа нартай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг Э.Нямдаваа, Ц.Батчимэг, М.Энхтуяа нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ